

БАТЛАВ: ЗАХИАЛАГЧ

"БОЛОВСРОЛЫН МЭДЭЭЛЛИЙН
ТЕХНОЛОГИЙН ТӨВ" УТУГ-ЫН
ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ЭНХБАТ

БАТЛАВ: ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ

"АЙ ТИ ЗОН" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ



У.ЭРДЭНЭБЯМБА

ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2024 оны 6 дугаар сарын 03 өдөр

№БМТТ/2024/138
IZI-343-24-011

Улаанбаатар хот

Нэг талаас "Боловсролын мэдээллийн технологийн төв" УТУГ РД: 6562469 (цаашид Захиалагч гэх)-ийг төлөөлж Дижитал шилжилтийн технологи хөгжүүлэлтийн хэлтсийн дарга М.Чойжилсүрэн,

Нөгөө талаас "АЙ ТИ ЗОН" ХХК РД: 2113155 (цаашид Үйлчилгээ үзүүлэгч гэх)-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал У.Эрдэнэбямба (хамтад нь Талууд гэх, дангаар нь Тал гэх) нар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дүгээр зүйлийн 30.1 дахь хэсэг, Иргэний хуулийн 343-358 дугаар зүйлийг үндэслэн доорх нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү гэрээний зорилго нь үйлчилгээ үзүүлэгч нь захиалагчид гэрээний хавсралтад заасан боловсролын салбарын их өгөгдлийн цахим систем хөгжүүлэх үйлчилгээ үзүүлэх, захиалагч нь үйлчилгээний төлбөрийг улсын төсвөөс, санхүүжилтийн хуваарийн дагуу гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийг үндэслэн төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү гэрээ нь Гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, гэрээг баталгаажуулах маягт, Хавсралт №1 "Ажлын даалгавар", Хавсралт №2 "Ажил дүгнэсэн тайлан", Хавсралт №3 "Гэрээ дүгнэсэн акт" болон талууд хамтран гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

1.3. Гэрээнд үйлчилгээ үзүүлэгчийн ажлын даалгавар, гүйцэтгэлийн баталгаа, тендерийн маягтыг хавсаргав.


ХОЁР. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

2.1. Захиалагч нь ажлын даалгаварт заасан үйлчилгээг авах эрхтэй.

2.2. Чанаргүй үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд үйлчилгээний доголдлыг нэн даруй арилгахыг шаардах эрхтэй. Мөн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасны дагуу алдангийг суутгаж, төлбөрийг шилжүүлэх эрхтэй.

2.3. Үйлчилгээний талаар санал, гомдлоо илэрхийлж гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллахыг үйлчилгээ үзүүлэгчээс шаардах эрхтэй.


Захиалагч


Үйлчилгээ үзүүлэгч

2.4. Захиалагч нь үйлчилгээг хүлээн авахад шаардлагатай зөвлөгөө, тайлбарыг авах эрхтэй.

2.5. Үйлчилгээ үзүүлэгчийн ажилтнуудаас нууцын баталгаа авах, нууцлалыг хадгалж ажиллах талаар шаардлага тавих эрхтэй.

2.6. Захиалагч нь үйлчилгээ үзүүлэгчээс ирүүлсэн төлбөрийн нэхэмжлэх, гэрээний Хавсралт №2-д заасан ажил дүгнэсэн тайланг үндэслэн, энэхүү гэрээний 5 дугаар зүйлд заасан хугацаанд үйлчилгээний төлбөрийг төлнө.

ГУРАВ. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Үйлчилгээ үзүүлэгч нь гэрээний хавсралт№1 техникийн тодорхойлолт буюу ажлын даалгаварт заасны дагуу тасалдалгүй, чанартай үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээнэ.

3.2. Гэрээ байгуулснаас хойш хугацаанд эрх бүхий байгууллагын шийдвэрээр гэрээний хавсралтад өөрчлөлт оруулах шаардлага үүссэн тохиолдолд талууд хамтран акт үйлдэж нэмэлт өөрчлөлт оруулна.

3.3. Гэрээнд заасан нөхцөлөөр үйлчилгээ үзүүлсний төлбөрийг захиалагч талаас нэхэмжлэн авах эрхтэй.

3.4. Үйлчилгээ үзүүлэгч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор бусад байгууллагатай хамтран ажиллах болон бусад хэлбэрээр гэрээ байгуулахгүй.

3.5. Үйлчилгээ үзүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

3.6. Үйлчилгээ үзүүлэх нийт ажилтнуудаас эрх бүхий байгууллагын баталсан загвар маягтын дагуу нууцын баталгаа гаргаж өгөх ба нууцлалыг хугацаагүйгээр хадгалах үүрэг хүлээнэ.

ДӨРӨВ. ТЕХНИКИЙН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭ

4.1. Талууд холболт, туршилт хийх тохиолдолд тухай бүр нь акт үйлдэж баталгаажуулна.

4.2. Талууд өөрийн сүлжээ, техникийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч ажиллана.

4.3. Талууд 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдөрт багтаан гэрээний Хавсралт №2-д заасан ажил дүгнэсэн тайлан, Хавсралт №3-т заасан гэрээ дүгнэсэн акт үйлдэж баталгаажуулна.

ТАВ. ТӨЛБӨР ТООЦОО

5.1. Гэрээт үйлчилгээний төлбөрт 2024 оны 12 дугаар сарын 15-ныг дуустал хугацаанд төлөх нийт үнэ НӨАТ орсон дүнгээр 434,450,000 /дөрвөн зуун гучин дөрвөн сая дөрвөн зуун тавин мянга/ төгрөг ба үйлчилгээ үзүүлэгчийн тухайн сарын ажлын гүйцэтгэлийг тайланг Захиалагч тал дүгнэн, сарын төлбөр болох 62.064,285.7 төгрөг (жаран хоёр сая жаран дөрвөн мянга хоёр зуун наян таван төгрөг долоон мөнгө)-ийг гэрээний 5.2-д заасны дагуу дараагийн сарын 15-ны өдөрт багтаан төлбөрийг шилжүүлнэ.

5.2. Захиалагч гэрээний Хавсралт №2-д заасан Ажил дүгнэсэн тайлан, үйлчилгээ үзүүлэгчийн төлбөрийн нэхэмжлэхийг тус тус үндэслэн Сангийн яамны санхүүжилтийн эрх нээгдсэн өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор төлбөрийг шилжүүлнэ.

5.3. Төлбөр шилжүүлэх санхүүгийн үндсэн баримт нь гүйцэтгэгчийн нэхэмжлэл, ажил хүлээлцсэн акт зэрэг байх бөгөөд эдгээр баримт зохих шаардлага хангаагүй эсвэл

.....
Захиалагч

.....
Үйлчилгээ үзүүлэгч

бүрдээгүй тохиолдолд төлбөр шилжүүлэх хугацааг сунгаж болно. Энэ хугацаанд захиалагч ямар нэг алданги торгууль хүлээхгүй.

5.4. Гэрээ дуусгавар болохоос өмнө Талуудын санхүүгийн ажилтнууд тооцоо нийлж, өр төлбөргүйг баталгаажуулна.

ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

6.1. Гэрээний хугацаа нь 2024 оны 6 дугаар сарын 03-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрийг дуустал хугацаанд хүчинтэй байна.

6.2. Гэрээ нь хоёр тал гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

ДОЛОО. ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

7.1 Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага гарсан тохиолдолд санал гаргаж буй тал нөгөө талдаа 30 /гуч/-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ.

7.2 Нэмэлт өөрчлөлт оруулах гэрээг бичгээр үйлдэн талуудын эрх бүхий төлөөлөгчид хамтран баталгаажуулж байгуулах бөгөөд нэмэлт гэрээ нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

7.3 Талууд гэрээний хүчинтэй хугацаанд гэрээний үнийг нэмэгдүүлэн өөрчлөхийг хориглох ба Үйлчилгээ үзүүлэгчийн хийж гүйцэтгэх ажил нь Гэрээний Хавсралт №1-т заасан Ажлын даалгавраар хязгаарлагдана.

НАЙМ. ГЭРЭЭ ЦУЦЛАХ

8.1. Гэрээний аль нэг Тал үүргээ зөрчсөн бол гэрээ цуцлах Тал нь нөгөө Талдаа 45 /дөчин тав/-аас доошгүй хоногийн өмнө гэрээ цуцлах тухай албан мэдэгдлийг хүргүүлсний дараа гэрээг цуцална.

8.2. Захиалагч дараах тохиолдолд гэрээг цуцлах эрхтэй. Үүнд:

8.2.1. техникийн тодорхойлолтын шаардлагыг хангахгүй үйлчилгээг 2 ба түүнээс удаа үзүүлсэн;

8.2.2. үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн чадваргүй болсон, эсхүл дампуурсан;

8.2.3. үйлчилгээ үзүүлэгч нь гэрээг хэрэгжүүлэх болон гэрээ байгуулах эрх олж авах явцдаа авлига, эсхүл залилан мэхлэх үйл ажиллагаанд холбогдсон нь шүүх, холбогдох байгууллагаар нотлогдсон.

8.3. Үйлчилгээ үзүүлэгч дараах тохиолдолд гэрээг цуцлах эрхтэй. Үүнд:

8.3.1. захиалагч гэрээнд заасан төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй бол.

8.4. Талууд гэрээг цуцалсан тохиолдолд захиалагч гэрээ цуцлагдсан өдөр хүртэлх хугацаанд үйлчилгээ үзүүлэгчийн хийж гүйцэтгэсэн ажлын үр дүнгийн тайлан, гэрээний Хавсралт №2-д заасан ажил дүгнэсэн тайлан, үйлчилгээ үзүүлэгчийн төлбөрийн нэхэмжлэхийг тус тус үндэслэн Сангийн яамны санхүүжилтийн эрх нээгдсэн өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор төлбөрийг шилжүүлнэ.

8.5. Гэрээг цуцалсан тохиолдолд захиалагч үйлчилгээний төлбөрөөс бусад аливаа төлбөр үйлчилгээ үзүүлэгч талд төлөх үүрэг хүлээхгүй.

8.6. Үйлчилгээ үзүүлэгч гэрээний үүргээ зөрчсөний улмаас гэрээг цуцлах тохиолдолд гэрээ цуцалсантай холбогдон учирсан хохирлыг Захиалагчаас шаардах эрхгүй.

ЕС. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА


.....
Захиалагч


.....
Үйлчилгээ үзүүлэгч

9.1. Талуудын буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан гэмтэл саатал болон Талуудын шийдвэрээс үүдэн гарч болох сөрөг үр дагаврын хариуцлагыг гэмтлийн шалтгааныг тодруулсан Талуудын инженер, техникийн ажилчид хамтран тогтоосон актыг үндэслэн буруутай тал нь бүрэн хариуцна.

9.2. Үйлчилгээ үзүүлэгч нь гэрээний 3 дугаар зүйлд заасан үүргийг гүйцэтгээгүй, зохих ёсоор гүйцэтгээгүй бол гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээгээр алданги төлнө. Захиалагч алдангийг үйлчилгээний төлбөрөөс хасаж үлдэгдэл төлбөрийг шилжүүлнэ.

9.3. Сангийн яамны санхүүжилтийн эрх нээгдээгүй тохиолдолд энэхүү гэрээний 5 дугаар зүйлийн холбогдох заалт санхүүжилтийн эрх нээгдэх хүртэл хугацаагаар хойшилно.

9.4. Талууд энэхүү гэрээг байгуулсантай холбоотой болон гэрээг хэрэгжүүлэх явцад шууд болон шууд бусаар олж мэдсэн байгууллага, хувь хүний нууцад хамааралтай (техник, санхүү, бизнесийн нууц гэх мэт) аливаа мэдээ, мэдээллийг бусдад аман, бичгийн болон аливаа бусад хэлбэрээр задруулахгүй байх үүргийг хугацаагүй хүлээнэ.

9.5. Энэхүү гэрээний 9.4-д заасан нөхцөлийг аль нэг тал зөрчсөн тохиолдолд үүнтэй холбоотойгоор үүсэх аливаа хохирлыг бүрэн барагдуулна.

АРАВ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

10.1. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талдаа ажлын 3 /гурав/ хоногийн дотор бичгээр, бичгээр мэдэгдэх боломжгүй бол боломжтой бусад хэлбэрээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

10.2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлийн нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

10.3. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио цээр зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаануудын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор, бүрэн гүйцэтгэх боломжгүй нөхцөл байдал үүссэн болохыг ойлгоно.

10.4. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талууд гэрээний үүргээ биелүүлээгүй эсхүл зохих ёсоор биелүүлээгүй бол хариуцлага хүлээхгүй.

АРВАН НЭГ. БУСАД

11.1. Энэхүү гэрээ болон түүнд оруулсан нэмэлт өөрчлөлтүүд нь Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

11.2. Энэхүү гэрээтэй холбогдон үүсэж болох аливаа маргаан, санал зөрөлдөөнийг Талууд эвийн журмаар шийдвэрлэх ба боломжгүй тохиолдолд Монгол улсын шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

11.3. Гэрээг 3 эх хувь үйлдэж захиалагч тал 2 хувь, үйлчилгээ үзүүлэгч нэг хувийг хадгалах ба гэрээний хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:



.....
Захиалагч


.....
Үйлчилгээ үзүүлэгч

Талууд энэхүү гэрээнд заасан бүхий л нөхцөл, заалтуудыг хүлээн зөвшөөрч байгаагаа нотлон доор гарын үсэг зурж баталгаажуулав.


Захиалагчийг төлөөлж:

ДИЖИТАЛ ШИЛЖИЛТИЙН ТЕХНОЛОГИ
ХӨГЖҮҮЛЭЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

 /М.ЧОЙЖИЛСҮРЭН/

Үйлчилгээ үзүүлэгчийг төлөөлж:

ТӨСЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА


/ Б.ОТГОНБИЛЭГ/

АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

 /Б.ЗОЛЖАРГАЛ/

ХУУЛЬЧ, ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ МЭРГЭЖИЛТЭН

 /Д.АЛТАНГЭРЭЛ/

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

- 1.1. Энэхүү гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл дор дурдсан утгыг агуулна:
 - 1.1.1. "Захиалагч" гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.2. "Захиалагчийн төлөөлөгч" гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Гүйцэтгэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;
 - 1.1.3. "Гүйцэтгэгч" гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.4. "Гүйцэтгэгчийн төлөөлөгч" гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Гүйцэтгэгчээс томилогдсон этгээдийг;
 - 1.1.5. "Талууд" гэж Захиалагч болон Гүйцэтгэгчийг хамтад нь нэрлэснийг;
 - 1.1.6. "Хууль" гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
 - 1.1.7. "Үйлчилгээ" гэж ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод заасан ажлыг;
 - 1.1.8. "Ажлын байр" гэж ажил гүйцэтгэж байгаа газрыг;
 - 1.1.9. "Баталгаат хугацаа" гэж гүйцэтгэсэн ажлыг ашиглах явцад ажилд илэрсэн доголдлыг Гүйцэтгэгч хариуцах хугацааг;


Захиалагч



Үйлчилгээ үзүүлэгч

Тайлбар

- 1.1.10. "Гомдлын шаардлага гаргах хугацаа" гэж Захиалагчаас баталгаат хугацаанд илрүүлсэн доголдолтой холбогдуулж Гүйцэтгэгчид шаардлага гаргах хугацааг;
 - 1.1.11. "Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал" гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио цээр тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.
- 1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:
- 1.2.1. Ганц тоогоор илэрхийлсэн үг нь олон тоон утгыг, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоон утгыг илэрхийлж болно.
 - 1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.
 - 1.2.3. Зүйл, заалт, үг өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томъёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.
 - 1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.
 - 1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.



Захиалагч



Үйлчилгээ үзүүлэгч

ХОЁР. ЗАХИАЛАГЧ

- | | |
|----------------------------|--|
| Захиалагчийн нийтлэг үүрэг | 2.1. Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авч, гэрээнд заасан хугацаанд үнийг төлнө. |
| | 2.2. Захиалагч хууль тогтоомж болон гэрээнд заасан баримт бичиг, зөвшөөрлийг Гүйцэтгэгчид зохих ёсоор гаргаж өгнө. |
| | 2.3. Захиалагч нь үйлчилгээ авахтай холбоотой гаргаж өгсөн ажлын даалгавар, техникийн нөхцөл зэрэг баримт бичгийн алдаатай холбоотой үр дагаврыг хариуцна. |
| Захиалагчийн төлөөлөгч | 2.4. Захиалагчийг төлөөлөн гүйцэтгэгчтэй харилцах, хяналт тавих төлөөлөгчийг Захиалагч томилно. |
| | 2.5. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээллийг Гэрээ баталгаажуулах маягтад заана. |
| | 2.6. Захиалагчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно. |
| Талбайд нэвтрэх зөвшөөрөл | 2.7. Захиалагч нь ажил эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд ажлын талбайд нэвтрэх, үйл ажиллагаа явуулах эрхийг Гүйцэтгэгчид бичгээр олгоно. |
| | 2.8. Ажлын талбайд нэвтрэх эрх олгоогүйгээс ажил гүйцэтгэх хугацаа хэтрэх болон түүнтэй холбоотой үүссэн аливаа үр дагаврыг Захиалагч хариуцна. |

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ

- | | |
|-----------------------------|---|
| Гүйцэтгэгчийн нийтлэг үүрэг | 3.1. Гүйцэтгэгч нь ажлыг техникийн тодорхойлолтод заасан шаардлагад нийцүүлэн гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж, Захиалагчид хүлээлгэн өгнө. |
| | 3.2. Гүйцэтгэгч нь ажлын талбайд ажиллах хүч (удирдах ажилтан, инженер, техникийн ажилтан гэх мэт) болон ашиглаж буй тоног төхөөрөмж, машин механизмын дэлгэрэнгүй жагсаалт, мэдээллийг Захиалагчид өгнө. |
| | 3.3. Ажил гүйцэтгэхэд шаардагдах материал, техник, тоног төхөөрөмж, машин механизм, сэлбэг хэрэгсэл, баримт бичгүүд, Гүйцэтгэгчийн түр ба байнгын ажлын байранд ажиллах ажилтан болон үйлчилгээг гүйцэтгэгч хариуцна. |
| | 3.4. Ажлын явцад шаардлагатай ус, хий, цахилгаан холбооны болон бусад хангамжийг Гүйцэтгэгч хариуцна. |
| | 3.5. Гүйцэтгэгч нь нийт ажлын 20 (хорь) хувиас дээш ажлыг Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй. |
| | 3.6. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй. |
| | 3.7. Гүйцэтгэгч нь захиалагч, түүний эрх олгосон этгээдийг ажлын талбайд чөлөөтэй нэвтрүүлэх үүрэгтэй. |



Захиалагч




Үйлчилгээ үзүүлэгч

- Гүйцэтгэгчийн төлөөлөгч 3.8. Гүйцэтгэгч нь Захиалагчтай харилцах эрх бүхий этгээдийг томилж, гэрээ баталгаажуулах маягтад заана.
- 3.9. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тухайн салбараар мэргэшсэн, дадлага туршлага бүхий хүн байна.
- 3.10. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.
- Техникийн болон ажлын талбайн өгөгдөл 3.11. Захиалагч нь үйлчилгээтэй холбоотой нөхцөл байдлын талаарх өөртөө байгаа бүх өгөгдөл мэдээллийг Гүйцэтгэгчид мэдээллийн журмаар ажил эхлэхээс өмнө өгнө.
- Аюулгүй байдал 3.12. Гүйцэтгэгч ажлын талбайд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Галын аюулгүй байдлын хууль зэрэг хөдөлмөрийн аюулгүй байдалд холбогдох бусад хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандарт, норм ба дүрмийг дагаж мөрдүүлнэ.
- 3.13. Гүйцэтгэгч нь ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангана.
- 3.14. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг байгалийн болон бусад хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаална.
- 3.15. Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.
- 3.16. Гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой үүссэн аливаа хариуцлагыг бүрэн хариуцна.
- 3.17. Гүйцэтгэгч нь ГЕН-ийн 3.19-3.22-т заасан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх аливаа үр дагаврыг бүрэн хариуцна.
- 3.18. Ажилд ашигласан эсхүл бий болгосон аюултай, хортой, бохирдсон материал, бодисыг холбогдох хууль тогтоомж, Захиалагчийн шаардлагын дагуу хадгалж, устгана.

ДӨРӨВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА, ЯВЦЫН ТАЙЛАН

- Ажил эхлэх 4.1. Гүйцэтгэгч нь ГТН-д заасан хугацаанд ажлыг эхлүүлж, ажлын хуваарийн дагуу гүйцэтгэнэ.
- 4.2. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө)-ийг ГТН-д заасан хугацаанд захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 4.3. Хөтөлбөрт ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажлыг эхлэхээс дуусах хүртэл ажлын үе шатны хугацааг болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан байна.
- 4.4. Хөтөлбөр (төлөвлөгөө)-т өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн төлөөлөгчид мэдэгдэнэ.
- Хугацаа сунгах 4.5. Гүйцэтгэгч дараах тохиолдолд ажил гүйцэтгэх хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:
- 4.5.1. ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон;


Захиалагч


Үйлчилгээ үзүүлэгч


- Ажлын явцын тайлан
- 4.5.2. холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт шинээр батлагдсан, өөрчлөгдсөн нь ажлын гүйцэтгэлд нөлөөлөхөөр байвал;
 - 4.5.3. Захиалагч хугацаандаа төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй;
 - 4.5.4. Захиалагч зөвшөөрөл, баримт бичиг гаргуулах хүргүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нь ажлын хугацаанд нөлөөлсөн.
 - 4.6. Гүйцэтгэгч хугацаа сунгах хүсэлтийг холбогдох нотлох баримтын хамт Захиалагчид ирүүлнэ.
 - 4.7. ГЕН-ийн 4.5.1-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Гүйцэтгэгч нотлох үүрэгтэй.
 - 4.8. Захиалагч ГЕН-ийн 4.5-д заасан үндэслэлийн аль нэг нь бүрдсэн тохиолдолд Гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.
 - 4.9. Гүйцэтгэгч ажлын явцын тайланг ГТН-д заасан хуваарийн дагуу гаргаж Захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
 - 4.10. Явцын тайланд үйл ажиллагаа бүрийн бодит гүйцэтгэлийн хувийг гаргаж, түүнийг төлөвлөсөн хувьтай харьцуулсан харьцуулалт, хийгдээгүй ажил байвал тухайн ажлын талаарх мэдээлэл, хэзээ хийх санал, Захиалагчийн төлөөлөгчийн шаардсан бусад мэдээллийг тусгана.
 - 4.11. Гүйцэтгэгч нь ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг ажиллуулж, техник үйлчилгээ хийх, задлах, буцаан угсрах, тохиргоо хийх болон засварлах талаар ашиглалт үйлчилгээний зааварчилгааг Захиалагчид гаргаж өгнө.

ТАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ БА ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- Гэрээний үнэ
- 5.1. Гэрээний үнийг гэрээ баталгаажуулах маягтад заана.
 - 5.2. Гэрээний үнэд хуулийн 11.11-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д тусгана.
 - 5.3. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.
- Урьдчилгаа төлбөр
- 5.4. Тендер шалгаруулалтын баримт бичигт урьдчилгаа төлбөр олгохоор заасан бөгөөд Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийн хүсэлт гаргасан бол Захиалагч урьдчилгаа төлбөрийг ГТН-д заасан хэмжээгээр олгоно.
 - 5.5. Захиалагч нь урьдчилгаа төлбөрийн баталгааг хүлээн авснаас хойш Гүйцэтгэгчид ГТН-д заасан хугацаанд урьдчилгаа төлбөр олгоно.
- Төлбөрийн нөхцөл
- 5.6. Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг төлнө.
 - 5.7. Захиалагч гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.



Захиалагч



Үйлчилгээ үзүүлэгч


- 5.8. Гүйцэтгэгчийн хүсэлтээр Захиалагч ажил хүлээлгэн өгөх хугацааг ГЕН-ийн 4.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.
- 5.9. Захиалагчийн төлсөн аливаа төлбөрийг ажил, түүний бүрэлдэхүүний хэсгийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэх үндэслэл болохгүй.
- 5.10. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.
- 5.11. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутгана.

ЗУРГАА. БАТАЛГАА БА БАТАЛГААТ ХУГАЦАА

- | | |
|-------------------------------|--|
| Урьдчилгаа төлбөрийн баталгаа | 6.1. ГЕН-ийн 5.4-д заасны дагуу урьдчилгаа төлбөр олгохоор бол ГТН-д заасан хэмжээний урьдчилгаа төлбөрийн баталгааг ГТН-д заасан хугацааны дотор хуульд заасан хэлбэрээр, холбогдох маягтын дагуу ирүүлнэ. |
| Гүйцэтгэлийн баталгаа | 6.2. Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Гүйцэтгэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Гүйцэтгэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ. |
| | 6.3. Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангуулна: <ul style="list-style-type: none"> 6.3.1. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй; 6.3.2. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй; 6.3.3. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон. |
| | 6.4. Захиалагч Гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулсан нь Гүйцэтгэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй. |
| | 6.5. ГЕН-ийн 4.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна. |
| Чанарын баталгаа | 6.6. Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 6.8-д заасан Чанарын баталгаа гаргаснаар Гүйцэтгэлийн баталгааг чөлөөлнө. |
| | 6.7. Үйлчилгээний чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно. Чанарын баталгаа гаргуулах бол чанарын баталгааны хэмжээг ГТН-д заана. |
| | 6.8. Гүйцэтгэгч Чанарын баталгааг хуулийн 42.5-д заасны дагуу баталгаажуулж болно. |
| | 6.9. ГЕН-ийн 6.9-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно. |
| | 6.10. Баталгаат хугацаанд үйлчилгээнд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө. |



Захиалагч



Үйлчилгээ үзүүлэгч


- 6.11. ГЕН-ийн 8.6-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Гүйцэтгэгчид олгоно.
- 6.12. ГЕН-ийн 8.5-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат болон гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.
- 6.13. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт баталгаат хугацаа тогтоох бөгөөд баталгаат хугацааг ГТН-д заана.
- 6.14. Захиалагч нь баталгаат хугацаанд илэрсэн доголдлыг арилгуулахыг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.

ДОЛОО. ЭРСДЭЛ БА ДААТГАЛ

- Бусдад учруулсан хохирлыг арилгах
- 7.1. Үйлчилгээ үзүүлэх хугацаанд Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч түүний эрх бүхий этгээдийн аливаа үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас бусдад эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол хохирлыг Гүйцэтгэгч хариуцна.
- 7.2. Захиалагч түүний эрх олгогдсон этгээдийн үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол Гүйцэтгэгч хариуцахгүй.
- Захиалагчийн хүлээх эрсдэл
- 7.3. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:
- 7.3.1. Үйлчилгээний үр дүнг захиалагчид шилжүүлснээс хойш ажлын үр дүн Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас гэмтсэн, устсан;
- 7.3.2. гүйцэтгэсэн үйлчилгээг хүлээлгэн өгөх мэдэгдэл өгсөн боловч захиалагч ажлыг хүлээн авах үүргээ биелүүлээгүйгээс ажил, түүний бүрэлдэхүүн хэсэг гэмтсэн, устсан;
- 7.3.3. Захиалагчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас үйлчилгээ, материал болон тоног төхөөрөмж гэмтсэн, устсан;
- 7.3.4. Захиалагчийн ажлын даалгаврын алдааны улмаас үүссэн аливаа эрсдэл.
- 7.4. Үйлчилгээний доголдлын улмаас захиалагч ажлын үр дүнг хүлээн авахаас татгалзсан бол ажлыг хүлээн авах хүртэлх хугацаанд бий болсон аливаа эрсдэлийг захиалагч хариуцахгүй.
- Даатгал
- 7.5. Гүйцэтгэгч нь ажлын явцад учирч болзошгүй эрсдэлийг ажил эхлэх өдрөөс дуусах хүртэл хугацаанд ГТН-д заасан даатгалд даатгуулна.
- 7.6. Захиалагч болон гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-ээс гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирч болзошгүй хохирлыг Гүйцэтгэгч даатгуулна.
- 7.7. Гүйцэтгэгч нь даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 7.8. Гүйцэтгэгч даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг ирүүлээгүй бол захиалагч уг даатгалын гэрээг



Захиалагч



Үйлчилгээ үзүүлэгч

байгуулж, даатгалын хураамжийг Гүйцэтгэгчээс гаргуулна.

- 7.9. Даатгалын нөхцөлийг Захиалагчийн төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөхийг хориглоно.

НАЙМ. ДОГОЛДОЛ, ДАЛД ДОГОЛДОЛ

Доголдлыг илрүүлэх,
арилгах

- 8.1. Гүйцэтгэгчээс ирүүлсэн үйлчилгээ, түүний хэсэг нь зөрчил, доголдолгүй байна.
- 8.2. Захиалагчийн төлөөлөгч үйлчилгээний явцад зөрчил, доголдолтой байж болзошгүй аливаа ажилд зөрчил, доголдлыг илрүүлэх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг Гүйцэтгэгчид өгнө.
- 8.3. Захиалагч хүлээж авсан ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт ГТН-д заасан баталгаат хугацааны дотор зөрчил, доголдол илэрвэл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлнэ.
- 8.4. Гүйцэтгэгч Доголдол арилгах тухай мэдэгдлийг хүлээн авмагц доголдол арилгах ажлыг эхлүүлнэ.
- 8.5. Доголдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр Гүйцэтгэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.
- 8.6. Гүйцэтгэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгаж болно.
- 8.7. Захиалагчийн гаргасан зардлыг Гүйцэтгэгч үл маргах журмаар төлнө.

Далд доголдол

- 8.8. Доголдлыг арилгах явцад ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг Захиалагч ашиглаж чадаагүй бол доголдлыг арилгах хугацаагаар баталгаат хугацаа сунгагдана.
- 8.9. Ажил хүлээн авсан баримт (акт) үйлдсэн ч ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт илэрсэн, далд доголдол, түүний улмаас үүссэн аливаа үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.

Зураг төслийн доголдол

- 8.10. Зураг төслийг Захиалагч боловсруулсан бол зураг төсөлтэй холбоотой аливаа асуудал (зураг төслийн үнэн зөв, түүнээс үүссэн ажлын доголдол гэх мэт)-ыг Захиалагч хариуцна.
- 8.11. Гүйцэтгэгч нь өөрийн гүйцэтгэсэн Ажлын зураг төсөл, холбогдох баримт бичгүүд, мэдээлэл ба өгөгдлүүдийн үнэн зөвийг хариуцна.

ЕС. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

Захиалагч гэрээг цуцлах

- 9.1. Захиалагч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:
- 9.1.1. Гүйцэтгэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр үйлчилгээ үзүүлээгүй;
- 9.1.2. Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацааг тогтоосон боловч үр дүн гараагүй;
- 9.1.3. Гүйцэтгэгч Гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн бусдад шилжүүлсэн, бусдаар гүйцэтгүүлсэн;



Захиалагч


Үйлчилгээ үзүүлэгч

- 9.1.4. Гүйцэтгэгч нь тендерт оролцохдоо буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авилгийн гэмт хэрэгт холбогдсон нь шүүх болон холбогдох байгууллагаар тогтоогдсон;
- 9.1.5. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;
- 9.1.6. Гүйцэтгэгч нийт ажлын 20 (хорь)-аас дээш хувийг нэг буюу түүнээс дээш туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлсэн;
- 9.1.7. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон.
- 9.1.8. Гүйцэтгэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй, эсхүл хуулийн этгээдийн хувьд тус нөхцөлийг хангахгүй болсон.
- 9.2. Захиалагч ГЕН-ийн 9.1-д заасан үндэслэлээс гадна хэдийд ч гэрээг цуцалж болно.
- 9.3. Гүйцэтгэгч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:
- 9.3.1. Захиалагч нь гэрээнд заасан үндсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бөгөөд тогтоосон нэмэлт хугацаанд биелүүлээгүй;
- 9.3.2. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;
- 9.3.3. Захиалагч нь ажлыг түр зогсоосон нь гүйцэтгэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхөөр бол.
- 9.4. Гэрээг цуцлах тал нь нөгөө талдаа үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.
- 9.5. Тогтоосон нэмэлт хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл нэмэлт хугацаа тогтоосон ч үр дүнд хүрэхгүй болох нь илт, ГЕН-ийн 4.8-т зааснаар хугацаа сунгагдсан бол Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.
- 9.6. Нэмэлт хугацаа тогтоох шаардлагагүй, нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэлд хариу ирүүлээгүй эсхүл тогтоосон хугацаанд зөрчлийг арилгаагүй тохиолдолд гэрээг цуцлах тал нь нөгөө талд гэрээг цуцлах мэдэгдэл хүргүүлнэ.
- 9.7. Гүйцэтгэгч ГЕН-ийн 9.6-т заасан мэдэгдлийг хүлээн авсан бол нэн даруй эсхүл мэдэгдэлд заасан хугацаанд ажлын гүйцэтгэсэн хэсгийг хамгаалах, ажлын талбайг цэвэр аюулгүй нөхцөлд үлдээхэд чиглэснээс бусад цаашид гүйцэтгэх бүх ажлаа зогсоож, Гэрээг цуцлах өдөр хүртэл гүйцэтгэсэн ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт холбогдох баримт бичгүүдийг Захиалагчид баримт (акт үйлдэн)-аар хүлээлгэн өгнө.



Захиалагч



Үйлчилгээ үзүүлэгч

Гэрээг цуцалсны дараах
төлбөр

- 9.8. ГЕН-ийн 9.1-д заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Гүйцэтгэгч гэрээг цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөрийг шаардах эрхтэй.
- 9.9. ГЕН-ийн 9.2-т заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Захиалагч гүйцэтгэгчид дараах төлбөрийг төлнө:
- 9.9.1. Гэрээ цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөр;
- 9.9.2. Ажлын талбайгаас Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг нүүлгэхтэй холбоотой үүссэн зардал;
- 9.9.3. Гэрээг цуцалсантай холбоотойгоор Гүйцэтгэгчээс туслан гүйцэтгэгчид төлөх шаардлагатай болсон аливаа төлбөр;
- 9.9.4. Гүйцэтгэгчээс ажлыг хамгаалах, ажлын талбайг цэвэр, аюулгүй нөхцөлд үлдээхэд зарцуулсан зардал;
- 9.9.5. Гэрээг цуцалсантай шууд холбоотой бусад зардал, учирсан хохирол.

АРАВ. БУСАД ЗААЛТ

Мэдэгдэл

- 10.1. Талуудын мэдэгдэл, зааварчилгаа, мэдээлэл болон бусад харилцаа төлөөлөгчөөр дамжина.
- 10.2. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.
- 10.3. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан төлөөлөгчийн хаягаар илгээнэ.
- 10.4. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:
- 10.4.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр төлбөр төлсөн баримтыг үндэслэн;
- 10.4.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.
- 10.5. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.
- 10.6. ГЕН-ийн 10.5-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.
- 10.7. Нэн даруй мэдэгдэх шаардлагатай яаралтай мэдэгдлийг ГЕН-ийн 10.2-т зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг дараа нь баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.



Захиалагч


Үйлчилгээ үзүүлэгч

Төлөөлөгч өөрчлөгдөх

10.8. Талууд төлөөлөгчийг өөрийн санаачилгаар өөрчилж болно.

10.9. Төлөөлөгч өөрчлөгдсөн тохиолдолд нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.

10.10. Мэдэгдэлд төлөөлөгчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаягийг заавал тусгасан байна.

10.11. Төлөөлөгч өөрчлөгдсөн мэдэгдлийг нөгөө талд хүргүүлснээр өмнөх төлөөлөгчийн эрх, үүрэг дуусгавар болно.

Үйлчилгээнд өөрчлөлт, залруулга хийх нөхцөл

10.12. Талууд үйлчилгээний чанар, үр ашиг, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор ажлын ерөнхий гүйцэтгэлийн хүрээнд хамаарсан, техник технологийн хувьд боломжтой бөгөөд гэрээний хугацаа, үнэд нөлөөлөхгүй бол ажилд өөрчлөлт оруулж болно.

10.13. Гүйцэтгэгч болон Захиалагч өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөрчлөлтийн төслийг гүйцэтгэгч гаргана.

10.14. Захиалагч төслийг үндэслэн ГЕН-ийн 10.12-т заасан нөхцөл, шаардлага хангасан гэж үзвэл өөрчлөлт хийх мэдэгдлийг хүргүүлнэ.

10.15. Захиалагчийн зөвшөөрөлгүй өөрчлөлт хийсэнтэй холбоотой техник, технологийн алдаа гарсан, гэрээний хугацаа хэтэрсэн, үнэ өссөн тохиолдолд үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.

Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал

10.16. Үйлчилгээг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Гүйцэтгэгч энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 10.7-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.

10.17. Гүйцэтгэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.

10.18. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцөж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.

10.19. Гэрээг хэрэгжүүлэх захиалагчийн зааварчилгаа, Гүйцэтгэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Гүйцэтгэгч ГЕН-ийн 4.5-д заасан хүсэлтийг гаргаж болно.



Захиалагч



Үйлчилгээ үзүүлэгч

- Оюуны өмчийн эрх зөрчих 10.20. Үйлчилгээг үзүүлэх явцад болон үйлчилгээ үзүүлсэнтэй холбоотойгоор гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсэн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.
- Алданги 10.21. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Гүйцэтгэгчид төлнө.
- 10.22. Гүйцэтгэгч нь үйлчилгээг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.
- 10.23. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.
- 10.24. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийн хамт өгнө.
- Маргаан шийдвэрлэх 10.25. Гэрээнээс үүссэн аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 10.26. Маргааныг зөвшилцөж, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.


.....
Захиалагч


.....
Үйлчилгээ үзүүлэгч

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 4.1.	Үйлчилгээ үзүүлж эхлэх хугацаа: 2024 оны 06 сарын 03-ний өдөр
ГЕН 4.2.	Үйлчилгээ үзүүлэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө) ирүүлэх хугацаа: 2024 оны 05 сарын 22-ний өдөр
ГЕН 4.9.	Үйлчилгээний явцын тайлан гаргах хуваарь болон ирүүлэх хугацаа: Улирал тутам
ГЕН 5.2.	Үнийн тохируулга: “Хийхгүй”
ГЕН 5.4.	Урьдчилгаа төлбөр олгох эсэх: “Үгүй”
ГЕН 5.5.	Урьдчилгаа төлбөр олгох хугацаа: “Үгүй”
ГЕН 5.6.	Төлбөрийг хэсэгчилсэн төлөх бол төлбөр төлөх үе шатны хугацаа: Үйлчилгээ үзүүлэгчийн нэхэмжлэх, ажлын тайланг үндэслэн төлбөрийг тухайн сард ногдох төлбөрийг дараагийн сарын 15-ний өдрүүдэд гэрээнд заасан харилцах дансанд бэлэн бусаар шилжүүлнэ.
ГЕН 6.1.	Урьдчилгаа төлбөрийн хэмжээ: [мөнгөн дүн бич] Урьдчилгаа төлбөрийн баталгаа ирүүлэх хугацаа: [он, сар, өдөр]
ГЕН 6.7.	Чанарын баталгаа: “Шаардана” Чанарын баталгааны хэмжээ: Гэрээний үнийн дүнгийн 5 хувь.
ГЕН 6.13.	Баталгаат хугацаа: “Шаардана” 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал
ГЕН 7.5.	Даатгал: Үзүүлэх үйлчилгээний онцлогийг харгалзан Гүйцэтгэгч даатгалд хамрагдах шаардлага гарсан тохиолдолд даатгалын зардлыг Гүйцэтгэгч хариуцна.
ГЕН 10.21.	Захиалагчийн төлөх алдангийн хувь: Алдангийн хувь: [хоног тутамд 0.01 хувь]
ГЕН 10.22.	Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь: Алдангийн хувь: [хоног тутамд 0.01 хувь]



Захиалагч



Үйлчилгээ үзүүлэгч

ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

"Боловсролын их өгөгдлийн цахим систем хөгжүүлэх үйлчилгээ"-ний гэрээ.

Дугаар № БМТТ/ БМТТ/20240103006

Улаанбаатар хот

Нэг талаас "Боловсролын мэдээллийн технологийн төв" УТҮГ (цаашид "Захиалагч" гэх), нөгөө талаас "Ай Ту Зон" ХХК (цаашид "Гүйцэтгэгч" гэх) нь Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд ажил гүйцэтгэх, дагалдах бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь "Үйлчилгээ" гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу гүйцэтгэх Үйлчилгээний үнэ нь **434,450,000** төгрөг (цаашид "гэрээний үнэ" гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Гүйцэтгэгч **Ай Ту Зон ХХК**-ийн харилцах **Худалдаа хөгжлийн** банкны **499026123** дугаар дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:
 - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - 3.2. Гүйцэтгэгч тендер илгээсэн маягт;
 - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
 - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
 - 3.5. Техникийн тодорхойлолт;
 - 3.6. Үйлчилгээ үзүүлэх хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
 - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр: Мягмарсүрэн
Нэр: Чойжилсүрэн
Албан тушаал: ДШТХ хэлтсийн дарга
Ажлын утас: 75772727
Гар утас:
Цахим шуудан: choijilsuren@edu.mn
 - 4.2. Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр: Баасанжав
Нэр: Отгонбилэг
Албан тушаал: Төслийн хэлтсийн дарга
Ажлын утас: 75888555
Гар утас: 88887015
Цахим шуудан: otgonbileg.b@itzone.mn

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Дижитал шилжилтийн технологи
хөгжүүлэлтийн хэлтсийн дарга
Ч.Чойжилсүрэн


[Гарын үсэг]


.....
Захиалагч

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Төслийн хэлтсийн дарга
Б. Отгонбилэг

[Гарын үсэг]


.....
Үйлчилгээ үзүүлэгч

"БМТТ" УТУГ болон "АЙ ТИ ЗОН" ХХК -ийн хооронд байгуулсан

БМТТ/2024 / IZI-343-24-011 тоот гэрээний Хавсралт №1


**БОЛОВСРОЛЫН ИХ ӨГӨГДЛИЙН ЦАХИМ СИСТЕМ БОЛОН ӨГӨГДЛИЙН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭРЭГЛЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР 2024 ОН**


№	Боловсролын шинжилгээний хэрэглээ (Use-cases)	Нэмэлт тодруулга, тайлбар,	Өгөгдлийн эх үүсвэр	Шинжилгээ Хэрэглэгч
1	Google Cloud Platform (GCP) дээр их өгөгдлийн дэд бүтэц үүсгэх. Үүнд: -Өгөгдлийн эх үүсвэрүүдийг тодорхойлох -Өгөгдлийн хэмжээ_ төрөл болон хэрхэн авахыг тодорхойлох -Big data архитектурыг тодорхойлох -Data pipeline угсрах -Staging орчинд өгөгдлийг цуглуулах холболтуудыг хийх -GCP storage-руу dataг дүүргэх Өгөгдөл бэлтгэх, Үүнд -ELT буюу өгөгдлийг цэвэрлэх, хувиргах -Data мартуудыг үүсгэх	- Төлөвлөлтөд анги бүлгийн дүүргэлтийг шалгуур үзүүлэлт болгон авах, -Коеффициент тооцох -Хүчин чадал ашиглалтын хувь -Хамран сургалтын хувь -Ээлжийн коеффициент - Хөрөнгө оруулалтын үр ашгийн коеффициент	-БШУЯ-ны хөрөнгө оруулалтын мэдээлэл, -СЯ-ны PIMIS өгөгдөл, -Зион School mapping системийн тооцооллын үр дүн, өгөгдөл, - Investment.edu. mn - esis.edu.mn - gis.edu.mn	1. Санхүү хөрөнгө оруулалтын төлөвлөлт хийх, төлөвлөлтийн мэргэжилтнүүд, 2. Хөрөнгө оруулалтын асуудлаар шийдвэр гаргах удирдлага,

.....
Захиалагч

.....
Үйлчилгээ үзүүлэгч

			<ul style="list-style-type: none"> - ҮСХ-ны хүн амын өсөлтийн тооцоолол - Бүсчилсэн хөгжлийн бодлого - Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 	
2	<p>Боловсролын салбарын мэдээллийн сангийн мета-өгөгдлийн сан үүсгэх. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Бизнесийн шинжилгээ - Өгөгдлийн сангийн мета-өгөгдлийн зураглал гаргах -Зураглалын дагуу холбогдох өгөгдөл эзэмшигчээс мета-өгөгдлийг цуглуулж, мета-сан үүсгэх - Шинжилгээнд мета-өгөгдлийн санг ашиглах заавар боловсруулах, санг ашиглах сургалт хийх. 			
3	<p>Өгөгдлийн шинжилгээний хэрэглээ 1: "School mapping"</p> <ul style="list-style-type: none"> - СӨБ, ЕБС үзүүлэлтийн шинжилгээ бүх түвшинд (хамран сургах тойрог) - МБТБ, ДБС (эрэлттэй ажил, мэргэжил) дашбоард хөгжүүлэлт - Хөрсөг оруулалтын дашбоард хөгжүүлэлт 			
4	<p>Өгөгдлийн шинжилгээний хэрэглээ 2: Элсэлт төгсөлтийн динамик:</p> <ul style="list-style-type: none"> - Шинээр элссэн сурагчид бүх түвшинд - Анги дэвшилт бүх түвшинд 	<p>-Их дээд сургуулийн элсэлтийн тоо, квот, ЕБС-ийн элсэлтийн шалгалт өгсөн мэргэжлийн индекс,</p>	<p>-БМТТ-ийн өгөгдөл</p> <p>-БҮТ-ийн өгөгдөл,</p>	<p>1. Боловсролын бодлого боловсруулагч,</p>


 Захиалагч


 Үйлчилгээ үзүүлэгч

	-ЭБС элсэгчдийн тоо сургуулийн багтаамж харьцуулах,	-ЭЕШ өгсөн шалгуулагчдийн дүн, 2013 оноос (БМТТ).	мэргэжилтнүүд, шийдвэр гаргагч, 2. Бүх шатны боловсролын байгууллагын удирдлага
<ul style="list-style-type: none"> - Анги улиралт бүр түвшинд - Завсардалт бүр түвшинд - СӨБ, ЕБС-ийн хамран сургалтын цэвэр, бохир жин - Төгсөлт бүх түвшинд - МБТС, ДБС-ийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт бүх түвшинд - Тэгш байдлын индекс 		<ul style="list-style-type: none"> -БМТТ. -БҮТ. -БШУЯ-аас багшийн холбогдох өгөгдөл 	<ul style="list-style-type: none"> 1. Багшийн асуудлаар бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч
<p>5</p> <p>Өгөгдлийн шинжилгээний хэрэглээ 3: Багшийн динамик</p> <ul style="list-style-type: none"> - Багшийн хомсдолын шинжилгээ - Багшийн шилжилт хөдөлгөөний шинжилгээ - Багшийн мэргэжлээр төгсөж буй ажиллах хүчний шинжилгээ - Багшийн цалин, урамшууллын шинжилгээ - СӨБ-ын стандартын шаардлага хангасан багшийн эзлэх жин 		<ul style="list-style-type: none"> - БҮТ. - Eduitel, Person системийн хэрэглэгчийн статистик үзүүлэлт (БСҮХ), - PISA-2022 шалгалтын өгөгдөл. 	<ul style="list-style-type: none"> 1. Боловсролын бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч
<p>6</p> <p>Өгөгдлийн шинжилгээний хэрэглээ 4: Сурагчийн сурлагын амжилт</p> <ul style="list-style-type: none"> - Улсын хэмжээнд. - Аймаг орон нутгийн түвшинд. - Сургуулийн түвшинд. - Сурагчийн сурлагын амжилтад нөлөөлөх хүчин зүйлсийн анализ. - Сурагчийн чадавх шинжилгээ - ЭЕШ гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн - ЭЕШ хөдөлмөр эрхлэлтийн харьцаа - ЕБС, МБТС, ДБС-ийн төгссөн суралцагчийн амжилтыг суралцсан жилтэй нь харьцуулах. 		<ul style="list-style-type: none"> -БШУЯ, БМТТ, БҮТ Гүйцэтгэлийн үнэлгээ, 	<ul style="list-style-type: none"> 1. Боловсролын асуудлаар бодлого
<p>7</p> <p>Өгөгдлийн шинжилгээний хэрэглээ 5: Сургалтын байгууллагын менежмент</p> <ul style="list-style-type: none"> - Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт. - Суралцагчийн хөгжил хамгаалал. 		<ul style="list-style-type: none"> -БМТТ. 	

.....
Захиалагч

.....
Уйлчилгээ үзүүлэгч

	<ul style="list-style-type: none"> - Багш, ажилтны тасралтгүй хөгжил (сургалтын байгууллагын хүний нөөцийн бүрдэл, шилжилт хөдөлгөөн бүх түвшинд) - Сургалтын орчин бүрдүүлэлт (сургалтын байгууллагад байвал зохих нөөц, одоо байгаа нөөцийн харьцуулалт) - Дотуур байрны үйлчилгээ, сургалтын стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан байгууллагын эзлэх жин бүх түвшинд, - Удирдлагын манлайлал, менежмент (Гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн бүх түвшинд), - Сургалтын байгууллагын нийгэм-эдийн засгийн индекс бүх түвшинд - Бусад үйлчилгээ, түүний хүртээмж. 	<p>-сургуулийн орчин, -хэрэглэгдэхүүн, -сургуулийн хүний нөөц, -төсөв, зарцуулалт, нөхөн хангалтын зардал, -дижитал дэд бүтэц, -номын сан, -сурах бичиг, -хоол үйлдвэрлэл</p>	<p>-БСҮХ, -Млаб</p>	<p>боловсруулагч, шийдвэр гаргагч, 2. Бүх шатны боловсролын байгууллагын удирдлага, 3. Мэргэжилтнүүд</p>
8	Шинжилгээний дашбоардын хэрэглэгчийн интерфэйсүүдийг гаргах.			

.....
Захиалагч

.....
Үйлчилгээ үзүүлэгч

1. Ажлын хуваарь

№	Хийгдэх ажлууд	Хугацаа										
		6	7	8	9	10	11	12				
1	Google Cloud Platform (GCP) дээр их өгөгдлийн дэд бүтэц үүсгэх.											
2	Боловсролын салбарын мэдээллийн сангийн мета-өгөгдлийн сан үүсгэх.											
3	Өгөгдлийн шинжилгээний хэрэглээ 1: "School mapping"											
4	Өгөгдлийн шинжилгээний хэрэглээ 2: Элсэлт төгсөлтийн динамик.											
5	Өгөгдлийн шинжилгээний хэрэглээ 3: Багшийн динамик											
6.	Өгөгдлийн шинжилгээний хэрэглээ 4: Сурагчийн сурлагын амжилт											

Reel

 Захиалагч

Amy

 Үйлчилгээ үзүүлэгч

7.	Өгөгдлийн шинжилгээний хэрэглээ 5: Сургалтын байгууллагын менежмент																			
8.	Шинжилгээний дашбоардын хэрэглэгчийн интерфэйсүүдийг гаргах.																			

АЖЛЫН ДААЛГАВРЫГ БАТАЛГААЖУУЛСАН:

Захиалагчийг төлөөлж:

"БОЛОВСРОЛЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТӨВ" УТУГ-
 ДИЖИТАЛ ШИЛЖИЛТИЙН ТЕХНОЛОГИ ХӨГЖҮҮЛЭЛТИЙН
 ХЭЛТСИЙН ДАРГА
 /М. ЧОЙЖИЛСҮРЭН/

Үйлчилгээ үзүүлэгчийг төлөөлж:

"АЙ ТИ ЗОН" ХХК-ИЙН ТӨСЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
 /Б. ОТГОНБИЛЭГ/

.....
 Захиалагч

.....
 Үйлчилгээ үзүүлэгч